

**Говьсүмбэр аймгийн Улсын бүртгэл, статистикийн газрын ил тод байдлыг ханган ажиллах 2016 оны төлөвлөгөөний
эхний хагас жилийн тайлан**

16.06.06

д/д	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт
Нэг. Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал		
1.1	Байгууллагын эрхэм зорилго үйл ажиллагааны стратеги зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ түүний үр дүнг цахим хуудас болон мэдээллийн самбарт тогтмол шинэчлэн ойлгомжтой байдлаар байршуулна.	Статистикийн хэлтсийн www.govisumber.nso.mn цахим хуудас шинэчлэгдэн www.govisumber.ubseg.gov.mn болсон ба бүх цэснүүдийг өөрчлөн байгууллагын эрхэм зорилго үйл ажиллагааны стратеги зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл зэргийг "Бидний тухай" цэсэнд шинэчилж өгсөн. Мөн газрын ил тод байдлын самбаруудыг тогтмол мэдээллээр шинэчилж байна.
1.2	Тухайн байгууллагаас үзүүлж байгаа төрийн үйлчилгээний арга хэлбэрийг боловсронгуй болгох чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байх	Сүмбэр сумын иргэний бүртгэлийн үйлчилгээг онлайн системд холбосон. Иргэний үнэмлэх шинээр авах, 25,45 насны сунгалт хийлгэсэн иргэдийн ИУБ-31 маягтын мэдээллийг онлайнаар дамжуулж эхэлсэн. Ингэснээр иргэний үнэмлэх хугацаанаасаа ирэх боломжийг бүрдүүлсэн. 1 сарын дотор ирдэг байсныг 14 хоногт ирэх боломжтой болсон.
1.3	Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хуулиар хориглоогүй аливаа мэдээллийг иргэдэд үнэ төлбөргүй, хүндрэл чирэгдэлгүй өгөх зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байх	Иргэний бичиг баримтын зөрчил арилгах сарын аян зохион байгуулсан. Энэ аянаар бичиг баримтаа үргэдүүлсэн иргэдэд торгуулийн арга хэмжээг хамгийн багаар торгосон, Нийт 123 хүн хамрагдсан. Сарын аян зохион байгуулах тухай орон нутгийн телевиз радиогоор сурталчилсан. Мөн сонгуулийн тухай хуулийн өөрийн байгууллагад хамааралттай зүйл заалтыг иргэдэд суртчилсан.
1.4	Нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэрээ тухай бүр Хууль зүй ямаар хянуулан, улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлсэн байх	Нийтээр дагаж мөрдөх шийдвэрийг УБСЕГ-аас Хууль зүйн ямаар тогтмол хянуулж байдаг.
1.5	Төрийн бодлогын баримт бичиг болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг боловсруулахдаа холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, иргэдийн саналыг авч, үндэслэлтэй гэж үзвэл төсөлд тусгадаг байх	Нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг УБСЕГ-аас санал авах зарчмаар нийт Улсын бүртгэл, статистикийн системийн байгууллагуудаас авч хэвшсэн бөгөөд хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актуудад тухай бүр нь санал өгч ажиллаж байна.
1.6	Санал, хүсэлт, өргөдөл, гомдол мэдээлэл хүлээн авах утас буюу хайрцаг дэвтэр ажиллуулан, түүний мөрөөр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байх	Байгууллагын хэмжээнд өргөдөл гомдлыг цахим, цаасан болон аман хэлбэрээр хүлээн авч бүртгэлийн дэвтэр хөтлөн ажиллаж байна. Мөн ирүүлсэн өргөдөл, гомдол, саналыг хүлээн авах нээлттэй утас 7054-3056, 7054-3306 дугаарын утаснуудыг тогтмол ажлын цагаар ажиллуулж байна.
1.7	Өргөдөл гомдлыг хуульд заасан хугацаанд шийдвэрлэж, хариуг өгч хэвшсэн байх	2016 оны эхний хагас жилийн байдлаар тус газарт 33 өргөдөл санал хүсэлт, 1 гомдол хүлээн авч, 29 өргөдөл 1 гомдлыг зохих хууль журмын дагуу шийдвэрлэсэн байна. Шийдвэрлэх шатандаа байгаа 4 өргөдлийг холбогдох мэргэжилтэнд шилжүүлээд байна.

Хоёр. Хүний нөөцийн бодлогын ил тод байдал

2.1	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журам боловсруулан хэрэгжүүлсэн байх	Төрийн жинхэнэ албаны боловсон хүчний хэрэгцээг төлөвлөх, хангалтыг зохион байгуулах талаар зохиож байгаа ажилд УБСЕГ-аас чиглэл авч ажиллаж байгаа бөгөөд тайлант онд хэлтсийн төрийн жинхэнэ албан хаагчийн сул орон тоо гараагүй болно. Тайлант онд УБСЕГ-ын даргаас нэгдсэн бүтэцтэй холбоотойгоор тушаал гарч Аймгийн улсын бүртгэл, статистикийн газар нэртэйгээр зохион байгуулагдаж Улсын бүртгэлийн хэлтэс, Статистикийн хэлтэс гэсэн 2 нэгжтэйгээр зохион байгуулагдаж, нийт орон тоо 17, гэрээт ажилтан 2 нийт 19 хүний орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна.
2.2	Байгууллагын хүний нөөцийн удирдлагын ил, тод, нээлттэй байдлыг хангах арга замыг хүний нөөцийн стратегид тусгасан байх	Тус газар нь төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөр болон албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах 2016-2018 оны хөтөлбөрийг тус тус батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.
2.3	Хүний нөөцийн стратегийн хэрэгжилтийг үнэлэх, шинэчлэх үйл ажиллагаанд албан хаагчдын оролцох боломжийг бүрдүүлсэн байх	"Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа, үйл ажиллагааг хангах, хөтөлбөр"-ийн хүрээнд 2016 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг газрын албан хаагчдаас санал авч төлөвлөгөөнд тусган төлөвлөгөөг газрын даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.
2.4	Байгууллагын соёл, зохион байгуулалт, үйл ажиллагааны нээлттэй байдлын талаархи сэтгэл ханамжийн судалгааг албан хаагчдаас жил бүр авч, дүнг ил тод танилцуулан, түүний мөрөөр шаардлагатай арга хэмжээ авсан байх	Газрын албан хаагчдын байгууллагын соёл, зохион байгуулалт, үйл ажиллагааны нээлттэй байдлын талаархи сэтгэл ханамжийн судалгааг жил бүр байгууллагын жилийн төлөвлөгөөнд тусган ажилладаг. 2016 оны эхний хагас жилийн байдлаар 45 сэтгэл ханамжийн судалгаа авсан байна.
2.5	Сул орон тооны зарыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нээлттэй зарласан байх	Тус газарт төрийн албан хаагчийн сул орон тооны захиалга 2016 оны 05 дугаар сарын байдлаар гараагүй байна.
2.6	Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр байгууллагын дотоод журамд өөрчлөлт оруулж, хэрэгжилтийг зохион байгуулсан байх	Байгууллага шинэчлэн зохион байгуулагдсантай холбогдон дотоод журмыг шинээр боловсруулан албан хаагчдаас санал авах шатанд явагдаж байна.
Гурав. Төсөв, санхүүгийн ил тод байдал		
3.1	Төсвийн төслийг боловсруулахдаа байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны зорилт, зорилго, тэргүүлэх чиглэлтэй нягт уялдуулсан байх	2017 оны Төсвийн төсөл боловсруулах хуулийн хугацаа болоогүй байна.
3.2	Үндэсний аюулгүй байдал болон төрийн нууцтай холбоотойгоос бусад байгууллагын тухайн жилийн төсөв, урьд оны төсвийн гүйцэтгэл, дараа оны төсвийн гүйцэтгэл, дараа оны төсвийн төслийг Монгол Улсын төсвийн ил тод байдал /www.iltod.gov.mn/ цахим хуудсаар болон бусад хэлбэрээр олон нийтэд мэдээлж, мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцлийг бүрдүүлсэн байх	Байгууллагын батлагдсан төсвийг ил тод байдлын самбар, шилэн дансны цахим хуудас болон газрын цахим хуудсанд байршуулсан.

3.3	Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайланг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж, иргэд, иргэний нийгмийн зүгээс төсвийн зарцуулалтанд хяналт тавих боломжийг хангасан байх	Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр ил тод байдлын самбар, шилэн дансны цахим хуудас болон газрын цахим хуудсанд байршуулсан. Санхүүгийн тайлан цахим хуудас болон ил тодын самбарт байршуулсан.
3.4	Байгууллагын санхүүгийн тайланд хийсэн 2015 оны аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлсэн байх	2015 оны Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг /Улсын бүртгэлийн хэлтэс, Статистикийн хэлтэс/ газрын цахим хуудас, шилэн дансны цахим хуудсанд болон ил тод байдлын самбарт байршуулсан.
3.5	Тухайн жилийн батлагдсан төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулсан тохиолдолд энэ тухай цахим хуудсаар болон бусад хэлбэрээр олон нийтэд мэдээлж, мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцлөөр хангасан байна.	2016 оны эхний 6 сарын байдлаар төсөвт өөрчлөлт ороогүй болно.
3.6	Зөвхөн хууль тогтоомжид заасан төлбөр, хураамжийг үйлчлүүлэгчээс авч, түүний хэмжээний тухай цахим хуудсаар болон бусад хэлбэрээр олон нийтэд мэдээлсэн байх	Хууль тогтоомжинд заасан төлбөр, хураамжийг үйлчлүүлэгчээс авч орлогыг ил тодын цахим хуудас болон ил тодын самбарт сар бүр байршуулсан
3.7	Үйлчилгээний хөлс болон төлбөр, хураамж авах хэлбэрийг боловсронгуй болгох чиглэлээр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байх	Иргэдэд төрийн үйлчилгээ үзүүлэхэд мөрдөгддөг үйлчилгээний үнэ тарифыг цахим хуудас болон үйлчилгээний зааланд тогтмол байршуулан ажиллаж байна.
Дөрөв. Төрийн болон орон нутгийн өмч, хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал		
4.1	Ил тод, шударга, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчимд суурилсан худалдан авах ажиллагааны бодлого баримтлан, байгууллагын дотор мөрдөх журмыг батлан, энэ талаар олон нийтэд мэдээлсэн байх	2015 оны 5 сарын 16 нд А/11 Худалдан авах үйл ажиллагааны журам батлан харилцагч байгууллагуудтай гэрээ байгуулан ажиллаж байна энэхүү журмыг Ил тодын цахим сайтанд мэдээллэсэн.
4.2	Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам болон тендерийн урилгыг хуульд заасны дагуу хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, цахим хуудас /www.e-procurement.mn/- т байршуулан, тогтмол шинэчилж байх	Тендер үгүй болно.
4.3	Үнэлгээний хороонд тухайн салбарын 2-оос доошгүй төрийн бус байгууллагын төлөөлөл /ашиг сонирхлын зөрчилгүй болохыг мэдэгдсэн бол/-ийг оролцуулсан байх	2016 оны эхний хагас жилийн байдлаар гүйлгээ гараагүй болно.
4.4	Тендерт оролцохыг сонирхогчдод тавих шалгуур үзүүлэлт болон гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан үндэслэлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу ил тод мэдээлсэн байна.	Тендер үгүй болно.
4.5	Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаархи товч мэдээллийг байгууллагын цахим хуудаст байршуулан, шалгарсан болон шалгарч чадаагүй шалтгаан нөхцөл, хуулийн үндэслэлийн талаар тодорхой танилцуулсан байх	Тендер үгүй болно.

4.6	Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг тухай бүр байгууллагын цахим хуудаст байршуулж хэвшсэн байх	Томилолт, бараа материал худалдан авалт, шатахууны тайланг сар бүр хийж шилэн дансны цахим хуудас, газрын цахим хуудас, ил тод байдлын самбарт байршуулсан.
4.7	Тендер шалгаруулах явцад илэрсэн зөрчлийн талаар тухай бүр байгууллагын цахим хуудаст байршуулж хэвшсэн байх	Тендер үгүй болно.
4.8	Худалдан авах ажиллагааны чиглэлээр холбогдох албан хаагчийг мэргэшүүлсэн байх	Өмч хамгаалах зөвлөлийн гишүүн Б.Удвалцэцэг 2015 онд Худалдан авах ажиллагааны сургалтанд хамрагдсан болно.
4.9	Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт байрлуулан, түүнтэй танилцах боломжийг бүрдүүлсэн байна.	Худалдан авах ажиллагаатай холбоотой аудитын дүгнэлт гараагүй болно.
4.1	Худалдан авах ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдлын тоо, тэдгээрийн товч агуулга, шийдвэрлэсэн байдлыг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт байрлуулан мэдээлсэн байх	Худалдан авах ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдол гараагүй болно.

ТАЙЛАН НЭГТГЭСЭН: МЭРГЭЖИЛТЭН *Эрдэнэзаяа* С.ЭРДЭНЭЗАЯА

